



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 14 өдөр

Дугаар

11/241

Мандалговь

Баримт нягтлан шалгах комисс  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ний өдрийн А/222 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 2.8, 2.9, 2.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Баримт нягтлан шалгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,

Гишүүдэд:

Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн нутгийн удирдлагын байгууллагын шийдвэр хариуцсан ахлах мэргэжилтэн,

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн нутгийн захиргааны байгууллага, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн

Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэнд х'н ам зүйн бодлого хариуцсан мэргэжилтэн,

Хууль, эрх зүйн хэлтсийн хууль тогтоомж, системчлэл, лавлагаа, хүний эрх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого хариуцсан мэргэжилтэн,

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн,

Санхүү, төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн,

Нарийн бичгийн дарга: Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Архив хариуцсан ажилтан

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх арга зүйн баримт бичгийг боловсруулах, хөтлөгдөж дууссан

48.2150588

хэргийг архивд шилжүүлэхэд бэлтгэх явцад баримтын үнэ цэнийг нягтлан шалгах ажлыг зааврын дагуу зохион байгуулахыг комиссын даргад үүрэг болгосугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А/26 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ